

Казахын алдарт хаан Абылайтай хамтран зүтгэсэн Хэрийд омгийн толгойлогч Ер Жанибек (1714-1792) баатрын 300 жилийн ойг Баян-Олгийчүүд есдүгээр сарын 13, 14-нд тэмдэглэхээр болов.

Ойг угтаж эрдэм шинжилгээний бага хурал зохиогдох богоод урлаг уран сайхан, биеийн тамирын олон торлийн арга хэмжээ хэрэгжүүлэхээр товлон байгаагийн нэгэн нь аймгийн товийн ойролцоо нэгэн толгой дээр эрэлхэг баатарын морьтой сүрлэг хошоо босгохоор иргэд хандив оргож эхлэв. Ер Жанибек бол хотгойдын Амарсанаа зэрэг үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний удирдагчидтай холбоо тогтоон тэмцэж байсан, хэрийдүүдийг уугуул нутаг Алтайдаа эргүүлэн суурьшуулсан томоохон гавъяатай хүн байсан тухай түүхэнд тэмдэглэгджээ. Ер Жанибекийн эелтэй цагаан тугийг хэрийдүүд хоёр зууны турш бишрэн шүтсээр ирсэнийг Дорнод Түрэгстаны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн нам дарагдсаны дараа хятадын аюулаас хамгаалах байгууллагынхан 1950-иад оны дундуур хураан авч хадгалсан байна.

Дашрамд нь дурдахад онгорсон арав хоногт Байтаг Богдын алдарт найман баатрын нэг дэслэгч Ж.Жанбилханы мэндэлсний 100 жилийн ой, Монгол Улсын начин Б.Хожогапаны мэндэлсний 100 жилийн ой, Даянгийн бага сургуулийг ууган багш М.Бекейн нэрэмжит болгосны ойг оргон тэмдэглэв.